

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүмбэр сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГСА-2024/01/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Говьсүмбэр аймаг
2024 он

Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа
Утас: 70543179
Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Наранбаяр
Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Анхтуяа
Цахим хаяг: ankhtuyab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: govsumber@audit.gov.mn

2024.05.25 № 50

танай _____ -ныг № _____ -Т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Сүмбэр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хамрагдсан "Энхтусдэм" өрхийн эрүүл мэндийн төв аудит хийлгэхээс татгалзсан тул тус байгууллагын санхүүгийн тайланг аудит хийж баталгаажуулаагүй, аудит хийгдээгүй санхүүгийн тайланг нэгтгэсэнтэй холбоотой нийт 1,113.3 сая төгрөгийн зөрчил илэрч, тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад

008020132

тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. ТЭЗ-тай байгуулсан жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 109 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 91.6 хувьтай гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мян.төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Тодруулга | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|------------|--|----------------|------------------------|------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | | 3,358,809.20 | 5,360,812.20 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 3а, 3б | 1,222,530.60 | 3,216,500.30 |
| 33 | АВЛАГА | 5а, 5б, 6а, 6б | 923,320.00 | 775,289.40 |
| 34 | УРЬДЧИЛГАА | 7а, 7б | - | 1,407.60 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 8а, 8б, 8в | 1,177,827.60 | 1,239,122.80 |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | 9а | 35,131.00 | 47,314.90 |
| 360 | БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ | 10 | - | 81,177.20 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | | 1,299,270.90 | 1,112,036.80 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 12а, 12б, 12в | 1,299,270.90 | 1,112,036.80 |
| 39200 | Биет хөрөнгө | | 1,218,558.80 | 1,032,239.30 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 13 | 80,712.10 | 79,797.50 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | | 4,658,080.20 | 6,472,849.00 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | | 67,337.40 | 87,476.80 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 15а, 15б | 67,337.40 | 87,476.80 |
| 41300 | Өглөг | 17а, 17б | 66,285.40 | 81,813.30 |
| 41400 | Урьдчилж орсон орлого | 18а, 18б | 1,052.00 | 5,663.50 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | | 4,590,742.80 | 6,385,372.10 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | | 4,590,742.80 | 6,385,372.10 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | | 966,728.50 | 966,728.50 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | | 3,097,339.20 | 5,215,822.50 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 526,675.00 | 202,821.20 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | | 4,658,080.20 | 6,472,849.00 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Тодруулга | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|------|--|-----------|------------------------|------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | | 8,804,411.20 | 9,478,981.10 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | | 5,007,981.90 | 6,796,946.20 |
| 110 | Орлогын албан татвар | | 4,262,975.80 | 5,774,767.50 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | | 4,262,975.80 | 6,029,138.30 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | | - | (254,370.80) |
| 113 | Хөрөнгийн албан татвар | | 345,985.70 | 506,529.30 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | | 399,020.40 | 515,649.40 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1а, 1б | 374,626.20 | 1,150,031.10 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | | 374,626.20 | 1,150,031.10 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | | 3,421,803.10 | 1,532,003.80 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 2а, 2б | 8,414,188.40 | 7,421,300.50 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 8,414,188.40 | 7,421,300.50 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 3,278,492.90 | 4,990,442.90 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 885,920.70 | 1,424,971.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 108,808.20 | 176,104.40 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 67,057.50 | 113,216.20 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 1,022,832.40 | 802,856.00 |
| 2105 | Нормативт зардал | | 239,789.60 | 156,003.50 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | | 20,698.50 | 25,899.80 |
| 2107 | Томилолт, зочны зардал | | 11,378.00 | 19,575.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 537,972.90 | 2,011,874.90 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 384,034.90 | 259,942.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 5,135,695.60 | 2,430,857.70 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | | 390,222.80 | 2,057,680.50 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | | 8,996,807.90 | 248,266.50 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | | (8,606,585.10) | 1,809,414.10 |

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Тодруулга | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|------|--|-----------|------------------------|------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | | 10,200,319.60 | 9,359,665.30 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | | 5,007,981.90 | 6,796,946.20 |
| 110 | Орлогын албан татвар | | 4,262,975.80 | 5,774,767.50 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | | 4,262,975.80 | 6,029,138.30 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | | - | (254,370.80) |
| 113 | Хөрөнгийн албан татвар | | 345,985.70 | 506,529.30 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | | 399,020.40 | 515,649.40 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | | 191,303.30 | 195,482.60 |
| 1181 | Газрын төлбөр | | 207,717.10 | 277,156.80 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | | - | 43,010.10 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | | 216,360.50 | 1,061,927.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | | 216,360.50 | 1,061,927.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | | 4,975,977.20 | 1,500,792.10 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | | 8,570,494.90 | 6,571,586.60 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 8,570,494.90 | 6,571,586.60 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 3,317,262.40 | 4,102,021.90 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 1,141,884.50 | 1,446,539.50 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 108,528.60 | 182,473.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 1,074,102.00 | 116,405.30 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 56,084.30 | 69,331.60 |
| 2105 | Нормативт зардал | | 68,782.10 | 80,191.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | | 84,539.40 | 54,389.80 |
| 2107 | Томилолт, зочны зардал | | 11,378.00 | 19,575.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 549,718.90 | 2,031,166.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 222,244.50 | 101,950.70 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 5,253,232.50 | 2,469,564.70 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | | 1,629,824.70 | 2,788,078.60 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | | 1,003,759.70 | 793,548.90 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | 1,003,759.70 | 793,548.90 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | | 1,003,759.70 | 793,548.90 |

| | | | | |
|------|---|--|-----------------------|---------------------|
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | | (1,003,759.70) | (793,548.90) |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | | (408,000.00) | (560.00) |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | | 408,000.00 | 560.00 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | | 218,065.00 | 1,993,969.70 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 1,004,465.60 | 1,222,530.60 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 1,222,530.60 | 3,216,500.30 |

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|------|---|--|-----------------------|------------------------|
| 1 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 13,204,855.70 | 0 | 13,204,855.70 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | -9,852.80 | 0 | -9,852.80 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 13,195,002.90 | 0 | 13,195,002.90 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 2,325.00 | 0 | 2,325.00 |
| 5 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 0 | 0 | 0 |
| 6 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0 | 0 | 0 |
| 7 | Өмчид гарсан өөрчилөлт | 0 | 0 | 0 |
| 8 | Зарласан ногдол ашиг | 0 | 0 | 0 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | -8,606,585.10 | 0 | -8,606,585.10 |
| 10 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 4,590,742.80 | 0 | 4,590,742.80 |
| 11 | 2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 4,590,742.80 | 0 | 4,590,742.80 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 309,069.20 | 0 | 309,069.20 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 4,899,811.90 | 0 | 4,899,811.90 |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | -323,853.90 | 0 | -323,853.90 |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 0 | 0 | 0 |

| | | | | |
|----|---|---------------------|----------|---------------------|
| 16 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0 | 0 | 0 |
| 17 | Өмчид гарсан өөрчилөлт | 0 | 0 | 0 |
| 18 | Зарласан ногдол ашиг | 0 | 0 | 0 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 1,809,414.10 | 0 | 1,809,414.10 |
| 20 | 2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл | 6,385,372.10 | 0 | 6,385,372.10 |

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан |
|------------|--|--------------------|-----------------------------|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 5,466,203.7 | 4,173,451.8 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 3,653,780.0 | 3,395,233.2 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,270,823.3 | 3,102,832.4 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 758,072.2 | 751,034.6 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 97,144.3 | 89,579.7 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 1,408,697.4 | 1,335,233.4 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 36,526.0 | 32,326.2 |
| 2105 | Нормативт зардал | 200.0 | 0.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 97,101.6 | 93,779.3 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 23,544.3 | 17,318.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 748,973.8 | 743,928.6 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 100,563.7 | 39,632.6 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 382,956.7 | 292,400.8 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 373,290.7 | 284,300.8 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 9,666.0 | 8,100.0 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 1,480,415.7 | 777,658.6 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 332,008.0 | 560.0 |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 5,466,203.7 | 4,846,526.7 |
| 31 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,496,153.7 | 1,469,187.1 |
| 32 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 3,385,829.0 | 3,198,609.5 |
| 35 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 584,221.0 | 178,730.1 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.0 | 375,373.8 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.0 | 1,048,448.7 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ТЗ цэвэр дүн |
|------------|--|---------------------|
| | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 31,605.0 |
| | УРСГАЛ ЗАРДАЛ | 29,955.0 |
| | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 29,910.0 |
| | Хангамж, бараа материалын зардал | 481.5 |
| | Бараа үйлчилгээний бусад зардал | 29,428.5 |
| | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 45.0 |
| | Бусад урсгал шилжүүлэг | 45.0 |
| | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 1,650.0 |
| | Дотоод эх үүсвэрээр | 1,650.0 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 31,605.0 |
| | Нэмэлт санхүүжилтийн орлого | 31,605.0 |

Гурав. Аудитын илрүүлэлт:

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар залруулга хийгдээгүй байна.

Аудитаар нийт 692.2 сая төгрөгийн 5 зөрчил¹ илэрснээс, 8.5 сая төгрөгийн 1 зөрчилд 1 төлбөрийн акт, 683.7 сая төгрөгийн 4 зөрчилд 3 зөвлөмж хүргүүлсэн байна.

Харьяа байгууллагууд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн, 1 “Энхтүсдэм” ӨЭМТ нийт 5 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 2 байгууллагад “Өөрчлөлтгүй” дүгнэлт гаргаж, 2 байгууллага түүвэрт хамрагдаж, “Энхтүсдэм” ӨЭМТ аудит хийлгэхээс татгалзаж аудитад шаардлагатай баримт материал ирүүлээгүй тул дүгнэлт өгөхөөс татгалзсан байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 602.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 172.8 сая төгрөгийн 11 алдааг аудитын явцад залруулж, 4.1 сая төгрөгийн 4 зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 393.3 сая төгрөгийн 2 зөрчилд 2 албан шаардлага, 32.0 сая төгрөгийн 4 зөрчилд зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмжийг хүргүүлсэн байна. /Хавсралт 1-ээс үзнэ үү/

Өмнөх онтой харьцуулахад харьяа байгууллагуудын нийт зөрчлийн дүн 13.2% буюу 91.6 сая, албан шаардлага 257.0 сая буюу 39.5%-иар буурсан, төлбөрийн акт 6 дахин буюу 3.5 сая, зөвлөмж 6 дахин буюу 27.8 сая төгрөгөөр тус тус өссөн байна. Нийт зөрчлийн дүн, албан шаардлагын бууралт нь Шилэн дансны тухай хууль болон бусад хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүйгээс шалтгаалсан байна.

Залруулагдаагүй нийт зөрчлийн 1,121.7 сая төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдлаас их тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

Төлбөрийн акт

1. ОНХС-гийн барьцаа дансанд барьцаа хөрөнгийн хугацаа дууссан, он удаан жил болсон, ажил дутуу хийгдсэний улмаас чөлөөлөх боломжгүй нийт 3 ажлын үлдэгдэл санхүүжилтийг шийдвэрлэж эргэлтэд оруулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 14 дүгээр зүйлийн 14.2.3, 15 дугаар зүйлийн 15.4.1 дэх заалтуудыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн орлогод төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: 2023 оны төсвийн тодотголоор Сүмбэр сумын ЗДТГ, Сүмбэр сумын ИТХ-ын төсвийг гүйцэтгэлд үндэслээгүй, тооцоо судалгаагүй их хэмжээгээр нэмэгдүүлж батлуулсан байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 15 дугаар зүйлийн 15.4, 15.4.1 дэх заалтуудыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тодотголоор харьяа байгууллагуудын төсвийг бодитой, үр ашигтай байхаар хүлээгдэж буй гүйцэтгэл, тооцоо судалгаанд үндэслэж батлуулах

2. Нэгтгэсэн тайлантай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: "Энхтусдэм" өрхийн эрүүл мэндийн төв аудит хийлгэхгүй шалтгаанаар баримт материалаа ирүүлээгүй тул дүгнэлт өгөхөөс татгалзсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9, 8.9.2, 8.9.3, 15 дугаар зүйлийн 15.4, 15.4.2 дахь заалтуудыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Гурвалсан гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүй байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг аудитад хамруулж, дүгнэлт гаргуулаагүй Энхтусдэм өрхийн эрүүл мэндийн төвийн удирдлагад холбогдох арга хэмжээг авах, байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд гэрээнд заасан чиг үүргийн дагуу хяналт шалгалт зохион байгуулах

3. Бусад хууль тогтоомжтой холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Сумын засаг дарга, Эрүүл мэндийн газрын дарга, Энхтусдэм өрхийн эрүүл мэндийн төвтэй 2023.04.17-ны өдөр байгуулсан гурвалсан гэрээг дүгнэхдээ аудитын дүгнэлтийг харгалзан үзээгүй, гэрээ дүгнэх хугацааг хуулиар заасан аудитын дүгнэлт гаргах хугацаатай уялдуулаагүйгээс аудитын дүгнэлттэй холбоотой үзүүлэлтийг бодитой үнэлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9, 8.9.2, 15 дугаар зүйлийн 15.4, 15.4.2 дахь заалтуудыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сумын Засаг дарга, Эрүүл мэндийн газрын дарга, Энхтусдэм өрхийн эрүүл мэндийн төвтэй байгуулсан гурвалсан гэрээний үүрэг хэсэгт "Аудитад хамрагдаж, дүгнэлт гаргуулах" талаар заалт нэмж оруулах, гэрээ дүгнэхэд аудитын дүгнэлтийг харгалзан үзэх, гэрээ дүгнэх хугацааг хуулиар заасан аудитын дүгнэлт гаргах хугацаатай уялдуулах

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|-------------------------------------|------------|--------------|-----------------------------------|-------------|--------------------------|-------------|------------|--------------|--------------|-----|---------|-----|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Сүмбэр сумын Засаг дарга | | | | | | | | | | | | |
| Сүмбэр сумын ИТХ | 3 | 1.9 | 1 | 1.2 | 2 | 0.7 | 3 | 1.9 | | | | |
| Сүмбэр сумын ЗДТГ | 6 | 64.7 | 2 | 6.2 | 4 | 58.5 | 6 | 64.7 | | | | |
| Сүмбэр сумын ОНХС | 2 | 106.2 | 1 | 81.2 | 1 | 25.0 | 2 | 106.2 | | | | |
| Сүмбэр сумын ХХС | | | | | | | | | | | | |
| Энх Тус Дэм ӨЭМТ | | | | | | | | | | | | |
| Дүн | 12 | 172.8 | 4 | 88.6 | 7 | 84.2 | 11 | 172.8 | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|-------------------------------------|-------------|-------|---------------|-----|-----------------|-----|---------|-------|--------------------------------------|---------------------|---|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Сүмбэр сумын Засаг дарга | 3 | 692.3 | 1 | 8.5 | | | 2 | 683.8 | | | | |
| Сүмбэр сумын ИТХ | 2 | 3.1 | 1 | 1.2 | | | 1 | 1.9 | | | | |
| Сүмбэр сумын ЗДТГ | 3 | 3.4 | 1 | 2.9 | 1 | 0.5 | 1 | 0.0 | | | | |

| | | | | | | | | | | | | |
|-------------------|-----------|----------------|----------|-------------|----------|--------------|----------|--------------|--|--|--|--|
| Сүмбэр сумын ОНХС | 1 | 392.8 | | | 1 | 392.8 | | | | | | |
| Сүмбэр сумын ХХС | 1 | 30.1 | | | | | 1 | 30.1 | | | | |
| Энх Тус Дэм ӨЭМТ | | | | | | | | | | | | |
| Нийт | 10 | 1,121.7 | 3 | 12.6 | 2 | 393.3 | 5 | 715.8 | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|--|-------------|------------|---------------|-----|-----------------|-----|----------|------------|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Сүмбэр сумын Засаг дарга | | | | | | | | |
| Сүмбэр сумын ИТХ | | | | | | | | |
| Сүмбэр сумын ЗДТГ | | | | | | | | |
| Сүмбэр сумын ОНХС | | | | | | | | |
| Сүмбэр сумын ХХС | | | | | | | | |
| Энх Тус Дэм ӨЭМТ | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Сүмбэр сумын Засаг дарга | | | | | | | | |
| Сүмбэр сумын ИТХ | 1 | 0.0 | | | | | 1 | 0.0 |
| Сүмбэр сумын ЗДТГ | | | | | | | | |
| Сүмбэр сумын ОНХС | | | | | | | | |
| Сүмбэр сумын ХХС | | | | | | | | |
| Энх Тус Дэм ӨЭМТ | | | | | | | | |
| Дүн | 1 | 0.0 | | | | | 1 | 0.0 |
| Нийт дүн | 1 | 0.0 | | | | | 1 | 0.0 |

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | | |
|---|-----------------------------|--------------------------|-----------------------------|--------------------|-------------------------|-----------|----------------|-------|----------------------------|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | | | | |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 5 | 2 | 3 | | 1 | | | 1 |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | | | | | | | |
| 3 | ЗГТС | | | | | | | | |
| 4 | ТТЗ | 1 | 1 | | | | 1 | | |
| 5 | ТЕЗ | | | | | | | | |
| | НИЙТ | 6 | 3 | 3 | | 1 | 1 | | 1 |

